



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 11578

Арвайхээр

Нэмэлт гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2, 35 дугаар зүйлийн 35.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4, 40 дүгээр зүйлийн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа Арвайхээр сумын Ерөнхий боловсролын “Тэмүүлэл эрдэм сургууль”-ийн 240 хүүхдийн өргөтгөлийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Сод Ээл” ХХК-ийн барилга угсралтын төсөвт өртөг нь барилгын материалын үнийн өсөлтөөс шалтгаалж өссөн тул 191,650, 530 (зуун ерэн нэгэн сая зургаан зуун тавин мянга таван зуун гуч) төгрөгийн нэмэлт гэрээ байгуулан барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлсүгэй.

2. Дээрх зардалд нэмэлт гэрээ байгуулан, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Т.Ариунболд)-д даалгасугай.

3. Нэмэлт ажилд шаардагдах санхүүжилтийг Сангийн яаманд уламжлан тендерийн үнийн зөрүү зардлаас шийдвэрлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101228